



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар Б/95

Чингис хот

Ажлаас түр чөлөөлөх тухай

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/-ын 136.4.2-ын “б” заалт, 136.5.2-ын “г” заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 26-ний өдрийн Б/338 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль сахиулах Их сургуулийн Цагдаагийн сургуулийн “Цагдаа-хууль сахиулах ажил” мэргэжлийн эчнээ 5 жилийн хөтөлбөрийн 5 дугаар дамжааны суралцагчдыг 2017-2018 оны хичээлийн жилийн сургалтанд суралцах Бор-Өндөр сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн жижүүрийн цагдаа, цагдаагийн ахлагч М.Мөнхбатыг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөн оны 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд ажлаас түр чөлөөлсүгэй.

2. Цагдаагийн ахлагч М.Мөнхбатын суралцах хугацаанд онцгой нөхцөлийн нэмэгдэлээс бусад үндсэн цалин, нэмэгдэлийг хэвээр бодож олгохыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

3. Цагдаагийн ахлагч М.Мөнхбатын суралцах хугацаанд үндсэн ажлыг алдагдуулахгүй ажиллахыг Бор-Өндөр сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Батхүүд үүрэг болгосугай.

4. Хууль сахиулах Их сургуулийн Цагдаагийн сургуульд суралцах хугацаандаа ирж буцах үеийн аюулгүй, байдлаа ханган хөдөлгөөнд оролцох, сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх, хичээл, сургалт таслахгүй, тогтоосон дүрэм, журмыг баримтлан мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг цагдаагийн Цагдаагийн ахлагч М.Мөнхбатад үүрэг болгосугай.

5. Тушаалын хуулбарыг хувийн хэрэгт нь хавсаргахыг Хүний нөөцийн мэргэжилтэн,

цэргийн ахмад П.Алтантуяаг үүрэг болгосой.

6. Тушаалыг нийт бүрэлдхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА
M. Batt
Ж.БОЛД